

“Монголын Нууц Товчоо”-ны 21-р зүйлийн англи орчуулгыг харьцуулан үзсэн нь

Ц.Алтангэрэл* (ШУА)

Хураангуй: “Монголын нууц товчоо” нь XIII зуунд дэлхийн ихэнх газар нутгийг эзэлж байсан Монголын Эзэнт гүрний түүх, Их Богд эзэн хаан Чингисийн талаар бичигдсэн цорын ганц хлвор нандин бүтээл билээ. Манай орны арвин их түүхийн нэгээхэн хэсэг болох энэхүү бүтээлийг дэлхий нийтийн түгээмэл хэл болох англи хэл рүү хөрвүүлсэн нь дэлхий даяар бидний түүхийн гайхамшгийг гайхан бишрэх ховорхог завшаан хэмээн үзэж байна. Энэхүү өгүүлэлд XIII зуунд хэвлэгдсэн Монголчуудын суут бүтээл Монголын нууц товчооны 21-р зүйл¹⁸¹-ийн В.Клийвэз, Йгор Де Рахевилз, Онон Өрөнгөө, Пол хаан нарын Англи орчуулгыг харьцуулан судалсан. **МНТ-ны 21-р зүйлийн цэгээн шар хүмүүн; гэрийн өрх, тотгын гэгээгээр; хэвлийг минь билиж /илбэж/, гараруун /гарахдаа/, наран сарны хилээр шар нохой мэт шарвалзаж гарах бүлгээ, хар тэргүүт хүн, харц хүн** зэрэг холбоо үг, өгүүлбэрийг хэрхэн орчуулсанг харьцууллаа¹⁸². Мөн хавсралтанд МНТ-ны хятад эхийг галиг уйгуржин монгол бичгийн хамт оруулсан болно.

Түлхүүр үг: Цэгээн шар хүмүүн, гэрийн өрх, тотгын гэгээ, наран сарны хил, шар нохой, хэвлий, шарвалзаж гарах, хар тэргүүт хүн, харц хүн, yellow man, light, smoke-hole, the beams, people, crawl out.

МНТ-ны 21-р зүйл

21. Шөнө бүр цэгээн шар хүмүүн гэрийн өрх, тотгын гэгээгээр орж ирээд хэвлийг минь билиж /илбэж/, гэгээн инү хэвэлд минь шингэх бүлгээ. Гараруун /гарахдаа/, наран сарны хилээр шар нохой мэт шарвалзаж гарах бүлгээ.

Дэлэмэ /дэмий/ яахан өгүүлэх, та /та нар/.

Түүгээр ухваас, тэмдэг инү тэнгэрийн хөвүүд буй зэ.

Хар тэргүүт хүнтэй адилтгаж яахин болно.

Хамгийн хаад болох цагт харц хүн сая учрыг мэднэ" гэв.

*ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, докторант

¹⁸¹ “Монголын нууц товчоо” эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг, х 13.

¹⁸² Ш. Чоймаагийн орчуулсан эхээс авав.

ЦЭГЭЭН ШАР ХҮМҮҮН – гэдгийг:

W. Cleaves

21. Every night, a bright yellow man entered by the light of the hole or [by that] of the door top of the tent and rubbed /илж үрэх/ my belly.

цэгээн шар хүмүүн a bright yellow man

Paul Kahn

21. Every night, a shining yellow man came into the yurt through the light of the smoke-hole and over the top of the door.

цэгээн шар хүмүүн shining /гэрэлтсэн/ yellow man

Urgunge Onon

21. Every night a man as yellow as the sun would enter my tent by the from smoke hole and over the top of the door.

yellow as the sun

Rachewiltz

21. Every night, a resplendent /гялалзсан гоёмсор/ yellow man entered by the light of the smoke-hole the door top of the tent.

цэгээн шар хүмүүн a resplendent /гялалзсан гоёмсор/ yellow man

[W. Cleaves]; a bright yellow man нэгэн цайвар шар хүмүүн-гэж орчуулсан

[Paul Kahn]; a shining yellow man гэрэлтсэн шар хүмүүн-гэж орчуулсан

[Urungo Onon]; a man as yellow as the sun нар мэт шар хүн-гэж орчуулсан

[Rachewiltz]; a resplendent yellow man гялалзсан шар хүн-гэж орчуулсан

ГЭРИЙН ӨРХ, ТОТГЫН ГЭГЭЭГЭЭР – гэдгийг:

[W. Cleaves]; by the light of the hole or [by that] of the door top of the tent¹⁸³ гэрийн /майхан, асар/ хаалганы дээрхи хэсэг болон нүхний гэгээ /туяагаар/... гэж орчуулсан.

[Paul Kahn]; through the light of the smoke-hole and over the top of the door - хаалганы дээд хэсэг болон утааны нүхний гэгээгээр нэвт/... гэж орчуулсан.

[Urungo Onon]; by the from smoke hole and over the top of the door - хаалганы дээд хэсэг болон утааны нүхээр... гэж орчуулсан.

[Rachewiltz]; by the light of the smoke-hole the door top of the tent - хаалганы дээд хэсэг болон утааны нүхний гэрлээр - гэж орчуулсан.

Дүгнэлт: Энд өрх гэсэн үгийн утгыг зөв илэрхийлэн гаргаагүй мэт.

Толь бичгээс харвал Өрх-covering for the smokehole of a gher, smoke-hole cover – хэмээж буй.

¹⁸³ Oxford Monsudar English Mongolian Dictionary, х 750

ХЭВЛИЙГ МИНЬ БИЛИЖ /ИЛБЭЖ/-гэдгийг:

W. Cleaves: ...rubbed /илж үрэх/ my belly.

Urungu. O: ...caressed /энхрийлэх/ my belly

ГАРАРУУН /ГАРАХДАА/, НАРАН САРНЫ ХИЛЭЭР ШАР НОХОЙ МЭТ
ШАРВАЛЗАЖ ГАРАХ БҮЛГЭЭ-гэсэн өгүүлбэрийг:

[W. Cleaves]; When he went out like a yellow dog he was wont to crawl out by the beams of the sun and the moon.

Тэр хүн наран сарны туяагаар шар нохой мэт шарвалзаж гарч одох бүлгээ

[Urungu Onon]; He [slunk] sheepishly away like a yellow dog by the light of the sun and moon.

Тэр хүн наран сарны туяагаар шар нохой мэт ичингүйрэн гарч явдаг билээ.

[Rachewiltz]; When he departed, he crept out on a moonbeam or a ray of sun in the guise of a yellow dog.

Тэр хүн гарахдаа нарны туяа, сарны гэрлээр шар нохой мэт чимээгүйхэн гарч одох бүлгээ.

ХАР ТЭРГҮҮТ ХҮН – гэдэг холбоо үгийг:

[W. Cleaves]; the people with black heads хар толгойтой хүмүүс - гэж орчуулсан.

[Urungu Onon]; the black-haired commoners хар үстэй эгэл хүмүүс - гэж орчуулсан.

[Rachewiltz]; ordinary black-headed men жирийн хар толгойт хүмүүс - гэж орчуулсан.

ХАРЦ ХҮН - гэдэг холбоо үгийгдээрх орчуулгад бүгд адилаар the common people - гэж орчуулсан байна.

Дүгнэлт

Энэ зохиолд эртний Монгол хэлний аялгуу ба үг холбон найруулах, шүлэглэсэн ба үргэлжилсэн зохиолын жишээ бүрэн гарсан хийгээд зүйрлэл, шилжсэн болон далд утга бүхий үг хэллэг олноор гарч буй. Жишээ нь энд яагаад заавал цэгээн шар хүн гэж хүнийг шар өнгөөр тодотгож өгсөн нь их учиртай санагдаж байна. Мөн шар нохой гэж нохойг бас шар өнгөөр тодотгож өгсөн байгаа. Өчүүхэн би-бээр сэтгэвээс, шар гэсэн өнгө нь ихэс дээдэс, сурвалжит болон язгууртан хүмүүнийг зүйрлэж дүрслэн хэлж буй мэт. Мөн хар тэргүүт хүн хэмээсэн нь хар царайтай хүнийг буюу зөвхөн хар үстэй хүмүүнийг бус жирийн ард иргэд гэсэн утгаар монгол хэлэнд хэрэглэгддэг. Үүний учир цэгээн шар хүн гэдгийг noble man хэмээн хөрвүүлбэл зохилтой, хар тэргүүт хүнийг the people with black heads, the black-haired commoners, ordinary black-headed men хэмээн орчуулсан нь англи хэлээр уншигчдын ой ухаанд хэрхэн буух нь илт бөгөөд харин the ordinary people гэж орчуулах аваас хэн нэг энгийн уншигч бүрэн төгс ойлгох буй. Ийнхүү дээрхи орчуулагч нар янз бүрийн утгаар орчуулжээ.

Ашигласан ном зүй:

1. Ш.Чоймаа, “Монголын нууц товчоо” эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг
2. W.Cleaves, “The Secret History of the Mongols, For the First Time Done into English out of the Original Tongue and Provided with an Exegetical Commentary” Harvard University Press, Cambridge, 1982
3. Urgunge Onon, “The Secret History of the Mongols, The Life and Times of Chinggis Khan” Cambridge, 2001
4. Igor De Rachewiltz, “The Secret History of the Mongols, A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century”, Brill, 2004
5. Paul Kahn, “The Secret History of the Mongols, The Origin of Chinghis Khan” North Point Press, San Francisco, 1984
6. Oxford Monsudar English Mongolian Dictionary, УБ 2004
7. Ц. Алтангэрэл, “Монгол Англи салаа утгатай хийгээд холбоо үгийн толь” УБ 2012
8. Emyr R. E. Pugh <http://www.linguamongolia.co.uk>

Хавсралт 1.

§21.

[21.1]	雪你惕	不里	超堅	失喇	古溫	客倫	額嚕客	朵脫恰因	客客額兒
	xue-ni-ti	bu-li	chao-jian	shi-la	gu-wen	ke-lun	e-lu-ke	dou-mo-ha-yin	ke-ke-e-er
	smnd	hurs		šara	gu'en	ger-un	ernke	dotoya-yin	kekeger
	韓驪周	客額里	米訥	必里周	客客延	亦訥			
	wo-ho-zhen	ke-e-li	mi-na	bi-li-zhou	ke-ke-yan	yi-na			
	oroju		mina						
	客額里	突兒	米訥	升格古	不列額				
	ke-e-li	tu-er	mi-na	sheng-ke-gu	bu-lie-e				
	namayi	har	mna	ke'ud	tone'elbei				
	哈魯輪	納蘭	撒喇因	乞里耶兒	失喇	那喀	幾圖	拭察班勒札周	
	ha-lu-lun	na-lan	salayin	qi-li-ye-er	shi-la	na-hai	mie-tu	shi-cha-ban-le-zha-zhou	
	qamqun	narar	sar-a-yin	ke'an	šara	naqni	metu		
	哈兒嚕	不列額	迭列篋	也勒	鳴訥列	塔			
	he-er-lu	bu-lie-e	die-lie-mie	ye-qa	wu-gu-lie-ti	ta			
	yarqn	hule'e	delem-e	yekin	uguled	ta			
	挑兀別兒	兀哈阿速	忒迭克	亦訥	騰吉哩因	可兀惕	備由者		
	tiao-wu-lie-er	wu-ha-ha-su	tie-die-ke	yi-na	teng-ji-li-yin	ke-wu-ti	beiyuzhe		
	tia'uber	uqa'asu	tedeg	ina	tenggiri-yin				
	哈喇	帖理兀禿	兀哈阿速	古溫	途兒				
	tiao-wu-lie-er	wu-ha-ha-su	tie-die-ke	gu-wen	tu-er				
	tia'uber	uqa'asu	tedeg	ina	tenggiri-yin				
	哈你惕	也勒鳴訥列	塔						
	tiao-wu-lie-er	wu-ha-ha-su	tie-die-ke						
	tia'uber	uqa'asu	tedeg						
	哈木惲	哈魯	李魯阿速						
	tiao-wu-lie-er	wu-ha-ha-su	tie-die-ke						
	tia'uber	uqa'asu	tedeg						
	哈喇除思	田迭	兀哈惕者	客額罷					
	tiao-wu-lie-er	wu-ha-ha-su	tie-die-ke	ke-e-li					
	tia'uber	uqa'asu	tedeg	ina	tenggiri-yin				

tende alan yau-a eke inu ügülebei "ta belgünütei, bügünütei qoyar köbegüd mino, namayi ede yurban köbegüd törgüdübei, "ken-fi yayun-u köbegüd buyu" kemen sereldün keleldünli. serekli-ber tann jöb!

ᠲᠡᠨᠳᠡ ᠠᠯᠠᠨ ᠶᠠᠭᠤᠨ ᠠ ᠡᠭᠡᠯᠡᠪᠡᠢ "ᠲᠠ ᠪᠡᠯᠭᠦᠨᠦᠲᠡᠢ, ᠪᠦᠭᠦᠨᠦᠲᠡᠢ ᠭᠣᠶᠠᠷ ᠬᠣᠪᠭᠡᠳᠦ ᠮᠢᠨᠣ, ᠨᠠᠮᠠᠶᠢ ᠡᠳᠡ ᠶᠤᠷᠪᠠᠨ ᠬᠣᠪᠭᠡᠳᠦ ᠲᠣᠷᠭᠦᠳᠦᠪᠡᠢ, "ᠬᠡᠨ-ᠶᠢ ᠶᠠᠶᠤᠨ-ᠤ ᠬᠣᠪᠭᠡᠳᠦ ᠪᠤᠶᠤ" ᠬᠡᠮᠡᠨ ᠰᠡᠷᠡᠯᠳᠦᠨ ᠬᠡᠯᠡᠯᠳᠦᠨᠢ. ᠰᠡᠷᠡᠬᠢ-ᠪᠡᠷ ᠲᠠᠨᠨ ᠵᠣᠪ!